

## БОЛЗОЛТ МАГИСТРЫН ЗЭРЭГ ОЛГОХ

Төрийн өмчийн их дээд сургуулийг 1993 оноос өмнө төгссөн төгсөгчдийн бакалаврын дипломыг магистрын дипломд дүйцүүлэн олгох тухай БСШУЯ-ны Сайдын 2006 оны 09-р сарын 6-ны өдрийн **“Магистрын зэргийн тухай”** 310 тоот тушаалыг үндэслэн МДА-наас гадаад, дотоодын их дээд сургуулийг 5 ба түүнээс дээш жил суралцлаж дээд боловсролын дипломын дундаж дүн ба диплом хамгаалалт эсвэл улсын шалгалтын дүн нь 4.0 ба түүнээс дээш үнэлгээтэй байх болзлыг хангасан, тухайн мэргэжлээр ажилласан дадлага туршлагыг нь харгалзан болзолт магистрын дипломыг дүйцүүлэн олгохоор болж, 2007-2008 оны хаврын улиралд энэ болзлыг хангасан 139 төгсөгчдөд болзолт магистрын зэргийг дүйцүүлэн олгоод байна.

1	Ректорын тушаалын дугаар	Тушаалын он, сар, өдөр	Болзолт магистрын зэрэг авч байгаа хүний тоо
1	67	2008.02.26	39
2	121	2008.04.16	43
3	177	2008.06.04	57
Бүгд			139